

БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН  
ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛ

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 2023 ОНЫ  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: БУА-2024/18-04-ШТА-ГА

БУЛГАН АЙМАГ  
2024

Булган дахь Төрийн аудитын газрын дарга,  
Тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ  
Утас: 7034-2580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn  
Аудитын менежер: Ж.Энхцоодол  
Утас: 7034-2716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn  
Ахлах аудитор: П.Содном  
Утас: 7034-2495 Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn  
Аудитор: З.Ганбаатар  
Утас: 7034-2716 Цахим хаяг: Ganbaatarz@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. [bulgan@audit.gov.mn](mailto:bulgan@audit.gov.mn)

Агуулга

Товчилсон үгийн тайлбар.....	3
хүснэгтийн товъёо .....	3
аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдээгдэл.....	4
а. булган аймагт шинээр эрх шилжсэн төсөл арга хэмжээ байхгүй, уих-ын 2021 оны 88 дугаар тогтоолын дагуу 930.7 сая төгрөгийг материалын үнийн зөрүүд олгожээ.....	5
а.1 орон нутаг шинээр хэрэгжиж эхлэх, эрх шилжсэн төсөл, арга хэмжээ байхгүй байна.....	5
а.2 бхб сайдын багцад баталсан сайхан сумын үерийн далангийн нэмэлт ажлын гүйцэтгэл 70 хувьтай үлдэгдэл санхүүжилт 80.5 сая төгрөгийг 2023 оны төсөвт тусгаагүй байна.....	5
а.3. уих-ын 2021 оны 88 дугаар тогтоолын дагуу материалын үнийн зөрүү олгохоор 2023 оны төсвийн тухай хуульд 930.7 сая төгрөгийг баталж 802.9 сая төгрөгийг олгосон байна.....	5-6
б. хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнээс 478.8 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ 70 хувийн гүйцэтгэлтэй бусад төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.....	6
б.1 байгалийн хүчин зүйлээс шалтгаалан 478.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээнд нэмэлт ажил гарч 70 хувийн гүйцэтгэлтэй ажил зогссон, бусад төсөл арга хэмжээ нь хэрэгжиж дууссан үйл ажиллагаа хэвийн явуулж байна.....	6-9
б.2. 2023 онд шинээр хэрэгжиж эхэлсэн ажил байхгүй, он дамжсан дуусаагүй 1 төсөл, арга хэмжээ нь тайлант онд зогссон тул хяналтын ажил хийгдээгүй байна.....	9
б.3 төбзг-ын 2023 оны 798 дугаар тогтоолоор 1278.5 сая төгрөгийн хөрөнгө бүртгэх шийдвэр гарсан ч ашиглагч байгууллага нбб-д тусгаагүй байна.....	9-10
в. хөрөнгө оруулалтын ажлууд хэрэгжиж, төрийн үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдсэн байна.....	10
в.1 улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж ашиглалтад орсон бүтээн байгуулалтын ажлууд нь үр ашгаа өгч, төрийн үйлчилгээний хүртээмж сайжирсан байна.....	10-11
в.2 хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүд нь орон нутагт хэрэгцээ шаардлагатай хөрөнгө оруулалтууд болсон байна.....	11-12
дүгнэлт.....	12
зөвлөмж.....	12

**Товчилсон үгийн тайлбар**

БОАЖС	Байгаль орчин аялал, жуулчлалын сайд
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТӨЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОБГ	Онцгой байдлын газар
СХАА	Санхүү хяналт аудитын алба
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
СТХС	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
БХБХ	Барилга, хот байгуулалтын хэлтэс
ТАХ	Төсөл арга хэмжээ
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах

**Хүснэгтийн товъёг**

<b>№</b>	<b>Тайлбар</b>	<b>Хуудасны дугаар</b>
Хүснэгт 1	2023 онд санхүүжилт олгосон төсөл, арга хэмжээ	
Хүснэгт 2	Ашиглалтад орсон, хүлээн авсан төсөл арга хэмжээ	
Хүснэгт 3	Нягтлан бодох бүртгэлд тусгасан төсөл арга хэмжээ	
Хүснэгт 4	Ашиглалтад орсон, үйл ажиллагаа явуулж байгаа бүтээн байгуулалтууд	
Хүснэгт 5	Төсөл, арга хэмжээний хэрэгцээ шаардлагын талаар	

<b>АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ</b>	
<b>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</b>	Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоолын дагуу хийлээ.
<b>Аудитын зорилт</b>	Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулж дүнг Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, санхүүжүүлсэн үү;</li> <li>- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж, хүлээн авсан уу;</li> <li>- Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн үү;</li> </ul>
<b>Аудитын хамарсан хүрээ</b>	Аудитад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 оноос эхэлсэн төсөл арга хэмжээнд 2023 онд санхүүжилт олгосон 6 төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны төв болон бусад байгууллага болон төсөл арга хэмжээг гүйцэтгэгч нарын холбогдох үйл ажиллагааг хамруулаа.
<b>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</b>	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-400, АДБОУС-3000-3100, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020, Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал, арга зүйг ашиглан ҮАГ-аас ирүүлсэн асуудлын шинжилгээ, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, судалгаа, дүн шинжилгээ хийж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
<b>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</b>	Аудитыг Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ хянан удирдаж, аудитын аудитын менежер Ж.Энхцоодол үе шатны чанарын хяналтыг хийж, ахлах аудитор П.Содном, аудитор З.Ганбаатар, Д.Даариймаа нар хийж гүйцэтгэлээ.  Аудитын удирдамжийн дагуу гүйцэтгэлийн аудитыг 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр хүртэл ажлын 15 хоногт хийж аудитыг үе шатны хяналтаар хянуулж аудитын тайланг хавсралт судалгааны хамт 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр ҮАГ-ын ГНАГ-т, аймгийн ЗДТГ болон ГХБХБГ-т тус тус хүргүүлэн ажилласан болно.
<b>Хүндрэл бэрхшээл</b>	Санхүүгийн тайлангийн аудитын хугацаатай давхцах ТБОНӨААН, ТТЗ-ийн санхүүгийн тайлангийн аудит 03 дугаар сарын 25-наар дуусгавар болсон.

**А. БУЛГАН АЙМАГТ ШИНЭЭР ЭРХ ШИЛЖСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ БАЙХГҮЙ, УИХ-ЫН 2021 ОНЫ 88 ДУГААР ТОГТООЛЫН ДАГУУ 930.7 САЯ ТӨГРӨГИЙГ МАТЕРИАЛЫН ҮНИЙН ЗӨРҮҮД ОЛГОЖЭЭ.**

**А.1 Орон нутаг шинээр хэрэгжиж эхлэх, эрх шилжсэн төсөл, арга хэмжээ байхгүй байна.**

УТХО-аар 2023 онд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээ байхгүй, эрх шилжиж ирсэн 6 төсөл арга хэмжээ нь 2020 оноос эхэлсэн, 5 төсөл арга хэмжээ нь бүрэн дуусаж ашиглалтад орсон, Сайхан сумын үерийн далангийн нэмэлт ажлын гүйцэтгэл 70 хувьтай байна.

2023 онд баталсан Хүүхдийн “Жаргалант” зуслангийн захиргаа, аж ахуй, гал тогооны барилга /Булган/ 313.9 сая, Булган сумын 3 дугаар цэцэрлэгийн барилгын 127.8 сая, Баян-агт сумын ЗДТГ-ын 134.8 сая, Ахмадын өргөөний барилга 268.2 сая, Сайхан сумын үерийн далан 47.7 сая, Гурванбулаг сумын цэцэрлэгийн барилгын 38.3 сая нийт 930.7 сая төгрөгийн санхүүжилт нь УИХ-ын 2021 оны 88 дугаар тогтоолын дагуу материалын үнийн зөрүү гарсан байна.

**А.2 БХБ сайдын багцад баталсан сайхан сумын үерийн далангийн нэмэлт ажлын гүйцэтгэл 70 хувьтай үлдэгдэл санхүүжилт 80.5 сая төгрөгийг 2023 оны төсөвт тусгаагүй байна.**

Орон нутагт эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээнээс Сайхан сумын үерийн далангийн /УХС-4 дүгээр/ ажлын явцад байгалийн гамшгаас үүдэн нэмэлт ажил гарсантай холбоотой БХТ, ГХБХГ, зураг төсөв зохиогч, гүйцэтгэгч компани хамтарсан хурал хийж зураг төсөвт магадлал хийлгэхээр шийдвэрлэн 2022 оны 03 дугаар сард магадлалаар хянуулан нэмэлт төсвийг БХБ-ны сайдын багцад 268.4 сая төгрөгийг баталж 2022 онд даланг хэлбэржүүлэх ажил хийгдэж ажлын гүйцэтгэл 70 хувьтай 187.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон, 2023 онд үлдэгдэл санхүүжилт 80.5 төгрөг батлагдаагүйгээс ажил зогссон байна.

**А.3. УИХ-ын 2021 оны 88 дугаар тогтоолын дагуу материалын үнийн зөрүү олгохоор 2023 оны төсвийн тухай хуульд 930.7 сая төгрөгийг баталж 802.9 сая төгрөгийг олгосон байна.**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 оноос хэрэгжиж эхэлсэн 6 төсөл арга хэмжээнд УИХ-ын 2021 оны 88 дугаар тогтоолын дагуу материалын үнийн зөрүү олгохоор 2023 оны төсвийн тухай хуульд 930.7 сая төгрөгийг баталсан байна.

**Хүснэгт № 1 2023 онд санхүүжилт олгосон төсөл, арга хэмжээ**

№	Төсөл арга хэмжээний нэр	2023 оны төсвийн тухай хуулиар		Олгосон санхүүжилт	Тайлбар
		Төсөвт өртөг	Тухай онд санхүүжих дүн		
1	Хүүхдийн “Жаргалант” зуслангийн захиргаа, аж ахуй, гал тогооны барилга	1233.9	313.9	313.9	2022 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн БД 88-0358/2022 дугаартай

	/Булган/				магадлалын дүгнэлт
2	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 75 ор /Булган, Булган сум, 3 дугаар цэцэрлэг/	1278.5	127.8		127 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан.
3	Засаг даргын Тамгын газрын барилга /Булган, Баян-Агт сум/	934.4	134.8	134.8	2022 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн БД 88-0399-2022 дугаартай магадлалын дүгнэлт
4	Ахмадын өргөөний барилга /Булган, Булган сум/	1,514.0	268.2	268.2	2022 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн БД 88-0326-2022 дугаартай магадлалын дүгнэлт
5	Үерийн далан /Булган, Сайхан сум/	478.8	47.7	47.7	2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 379/2022 дугаартай магадлалын дүгнэлт
6	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 75 ор /Булган, Гурванбулаг сум/	1,042.3	38.3	38.3	2022 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн БД 88-0178/2022 дугаартай магадлалын дүгнэлт
	Дүн	6481.9	930.7	802.9	

Булган сумын 3 дугаар цэцэрлэгийн материалын үнийн зөрүү 127.8 сая төгрөгийг дулааны шугам, халаалтын зуухны ажлууд өөрчлөх, нэмж тавих ажил хийгдээгүйгээс барьцаа хөрөнгийн дансанд байршуулж, бусад 5 төсөл арга хэмжээний 802.9 сая төгрөгийг магадлалын дүгнэлтийг үндэслэн санхүүжилтийг гүйцэтгэгчдэд бүрэн олгосон байна.

**Б. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНЭЭС 478.8 САЯ ТӨГРӨГИЙН 1 ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ 70 ХУВИЙН ГҮЙЦЭТГЭЛТЭЙ БУСАД ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ БҮРЭН ХЭРЭГЖСЭН БАЙНА.**

**Б.1 Байгалийн хүчин зүйлээс шалтгаалан 478.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээнд нэмэлт ажил гарч 70 хувийн гүйцэтгэлтэй ажил зогссон, бусад төсөл арга хэмжээ нь хэрэгжиж дууссан үйл ажиллагаа хэвийн явуулж байна.**

2023 онд санхүүжилт авсан, эрх шилжин ирсэн дараах 6 төсөл арга хэмжээ нь 2020 оноос хэрэгжиж эхэлсэн 2021 онд 2556.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2, 2022 онд 2168.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээ нь бүрэн дуусаж улсын комисс хүлээж авсан байна.

Булган сумын 3 дугаар цэцэрлэгийн барилгын 1278.5 сая төгрөгийн ажил дуусаж 2022 оны 12 дугаар сард улсын комисс ажиллаж, дулааны шугам, халаалтын зуухны ажлууд өөрчлөх, нэмж тавих ажил зэрэг ажлуудыг хийж дуусгах үүрэг

даалгавар өгсөн ч биелэлт хангалтгүй байна. Тус цэцэрлэг нь 2023 оны 09 дүгээр сараас үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна.

Хүснэгт № 2 *Ашиглалтад орсон, хүлээн авсан төсөл арга хэмжээ*

№	Төсөл арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	Гэрээний дүн	Хүлээн авсан
		Эхлэх	Дуусах			
1	Хүүхдийн “Жаргалант” зуслангийн захиргаа, аж ахуй, гал тогооны барилга /Булган/	2020	2023	1233.9	1233.9	№41/2022 2022.12.19
2	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 75 ор /Булган, Булган сум, 3 дугаар цэцэрлэг/	2020	2023	1278.5	1278.5	Дахиж комисс томилж ажиллана.
3	Засаг даргын Тамгын газрын барилга /Булган, Баян-Агт сум/	2020	2023	934.4	934.4	№23/2022 2022.09.15
4	Ахмадын өргөөний барилга /Булган, Булган сум/	2020	2023	1,514.0	1,514.0	№22/2021 2021.11.08
5	Үерийн далан /Булган, Сайхан сум/	2020	2023	478.8	478.8	Ашиглалтад ороогүй
6	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 75 ор /Булган, Гурванбулаг сум/	2020	2023	1,042.3	1,042.3	№13/2021 2021.10.12
	Дүн			6481.9	6481.9	

Бүрэн дуусаагүй 2 төсөл арга хэмжээг авч үзвэл дараах байдалтай байна.

**Булган сумын 3 дугаар цэцэрлэгийн барилга:** “Виртуалсофт” ХХК 905.0 сая төгрөгөөр 2020 оны 06 дугаар сарын 30-наас 2021 оны 11 дүгээр сарын 02-ны дотор хийж гүйцэтгэхээр гэрээг байгуулсан ч ковид цар тахалтай холбоотой бараа материалын хомсдол үүссэн тул гэрээг сунгах хүсэлт гаргаж 2022 онд дуусгахаар гэрээ байгуулсан байна.

Барилгын ажлыг хүлээн авах улсын комиссыг ГХБХБГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/107 тушаалаар 15 хүний бүрэлдэхүүнтэй томилон, ажиллаж 49/2022 тоот дүгнэлт гаргаж үүрэг даалгавар өгч гэрээг 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдөр хүртэл сунгасан байна.

2023 онд дулааны шугам ажлыг хийж барилгад халаалт өгч, үйл ажиллагаа явуулж байгаа хэдий ч тус барилгыг хүлээж авах комиссын үүрэг даалгавар, хурлын тэмдэглэлд туссан ажлуудыг бүрэн гүйцэт дуусаагүйгээс 2023 онд баталсан санхүүжилт 127.8 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд авч ажил дуусаж дахин комисс ажиллаж хүлээн авсны дараа олгохоор байршуулсан байна.

**Үерийн далан /Булган, Сайхан сум/:** Сайхан сумын үерийн далангийн ҮХС-4 дүгээр ажлын явцад байгалийн гамшгаас үүдэн нэмэлт ажил гарсантай холбоотой

дүгнэлт гарч магадлалаар хянуулан нэмэлт төсвийг БХБЯ-ны сайдын багцад 268.4 сая төгрөгийг баталж 2022 онд далангийн хэлбэржүүлэх ажил хийгдэж ажлын гүйцэтгэл 70 хувьтай 187.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон, 2023 онд үлдэгдэл санхүүжилт 80.5 сая төгрөг батлагдаагүйгээс ажил зогссон байна.

Үерийн далангийн ажлын явц



*Бүрэн дууссан барилга байгууламжууд*

*Засаг даргын Тамгын газрын барилга*

*Булган, Баян-Агт сум/*

*Ахмадын өргөөний барилга*



Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 75 ор

/Булган, Гурванбулаг сум/

Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 75 ор

/Булган, Булган сум, 3 дугаар цэцэрлэг



**Б.2. 2023 онд шинээр хэрэгжиж эхэлсэн ажил байхгүй, он дамжсан дуусаагүй 1 төсөл, арга хэмжээ нь тайлант онд зогссон тул хяналтын ажил хийгдээгүй байна.**

**Б.3 ТӨБЗГ-ын 2023 оны 798 дугаар тогтоолоор 1278.5 сая төгрөгийн хөрөнгө бүртгэх шийдвэр гарсан ч ашиглагч байгууллага НББ-д тусгаагүй байна.**

2023 онд эрх шилжиж санхүүжилт олгогдсон 6,481.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл арга хэмжээ нь 2020 онд хэрэгжиж эхэлсэн үүнээс 2022 онд 3,490.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл арга хэмжээг, 2023 онд 1,233.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл арга хэмжээг холбогдох байгууллагын шийдвэрийг үндэслэн данс бүртгэлд тусгасан,

Булган сумын 3 дугаар цэцэрлэгийн 1,278.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилгыг бүртгэлд тусгах ТӨБЗГ-ын тогтоол гарсан ч ашиглагч байгууллага бүртгэлд тусгаагүй байна.

Хүснэгт № 3 Нягтлан бодох бүртгэлд тусгасан төсөл арга хэмжээ

№	Төсөл, арга хэмжээний		Бүртгэлд тусгасан			
	Нэр	Гэрээний дүн	Байгууллага	Мөнгөн дүн	шийдвэрийн огноо дугаар	зөрүү
1	Хүүхдийн “Жаргалант” зуслангийн захиргаа, аж ахуй, гал тогооны барилга /Булган/	1,233.90	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар	920.0	Аймгийн ИТХ-ын 2023.06.21-ний өдрийн XVI/11	313.9
2	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 75 ор /Булган, Гурванбулаг сум/	1,042.29	Гурванбулаг сумын цэцэрлэг	995.9	ТӨБЗГ-ын 2022.05.10	38.3
3	Засаг даргын Тамгын газрын барилга /Булган, Баян-Агт сум/	934.40	Баян-Агт сумын ЗДТГ	799.6	2022.09.12-ны хүлээн авах комисс дүгнэлтийг үндэслэж	134.8

					орлогод авсан	
4	Ахмадын өргөөний барилга /Булган, Булган сум/	1,514.00	Аймгийн ЗДТГ	1245.8	Аймгийн ИТХ-ын 2022.09.28-ний өдрийн XI/08	268.2
	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 75 ор /Булган, Булган сум, 3 дугаар цэцэрлэг/	1278.5			ТӨБЗГ-ын 2023.12.26-ний 798 дугаар тогтоол	
	ДҮН	4,724.6		3961.3		755.2

Дээрх 4 төсөл, арга хэмжээний бүртгэлд тусгасан дүнгийн зөрүү УИХ-ын 2021 оны 88 дугаар тогтоолын дагуу материалын үнийн өсөлтөд 2023 онд олгосон 755.2 сая төгрөгийг бүртгэлд нэмж тусгаагүйтэй нь НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:” 14.4.2-д “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;” заалттай нийцэхгүй байна.

Булган сумын 3 дугаар цэцэрлэгийн барилгын өргөтгөлийг данс бүртгэлд тусгах тухай ТӨБЗГ-ын 2023 оны 798 дугаар тогтоол гарсан ч ашиглагч байгууллага нь комиссын дүгнэлтээр зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах ажил гүйцэтгэх байсан боловч заасан хугацаанд бүрэн хэрэгжүүлээгүй гэж үзэн бүртгэлд тусгаагүй гэсэн тайлбар ирүүлсэн байна.

## **В. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖЛУУД ХЭРЭГЖИЖ, ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖ НЭМЭГДСЭН БАЙНА.**

**В.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж ашиглалтад орсон бүтээн байгуулалтын ажлууд нь үр ашгаа өгч, төрийн үйлчилгээний хүртээмж сайжирсан байна.**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжсэн 6 төсөл арга хэмжээнээс зураг төсөв гэрээний дагуу хэрэгжсэн барилга байгууламжийг зориулалтын дагуу ашиглаж, үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

Хүснэгт № 4 Ашиглалтад орсон, үйл ажиллагаа явуулж байгаа бүтээн байгуулалтууд

№	Төсөл арга хэмжээний нэр	Үйл ажиллагааны талаар
1	Хүүхдийн “Жаргалант” зуслангийн захиргаа, аж ахуй, гал тогооны барилга /Булган/	Захиргаа, аж ахуй, гал тогооны үндсэн барилгыг барьсан
2	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 75 ор /Булган, Булган сум, 3 дугаар цэцэрлэг/	2023 онд үйл ажиллагаа явуулж эхэлсэн 22 ажилтан албан хаагчтай 4 бүлэг 50 хүүхэд хамруулсан, үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.
3	Засаг даргын Тамгын газрын барилга /Булган, Баян-Агт сум/	Захиргааны барилга, үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

4	Ахмадын өргөөний барилга /Булган, Булган сум/	2022 онд ашиглалтад орсон аймгийн хэмжээнд 18 хороо, 25 зөвлөл, 17 хэсэгт 220 гаруй идэвхтэн ажиллаж байна. шинээр ашиглалтад орсон ахмадын өргөөний барилгад чийрэгжүүлэлт, ахмадын эмч, бариа засал, бүжгийн танхим нь байнгын үйл ажиллагаа явуулж байна.
5	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 75 ор /Булган, Гурванбулаг сум/	2022 онд үйл ажиллагаа явуулж эхэлсэн шинээр барьсан өргөтгөлд 3 бүлэг 75 хүүхэд хамруулсан нийт цэцэрлэгийн хувьд 5 бүлэг 100-125 хүүхэд тогтмол хамрагдаж байна.

Дээрх төсөл, арга хэмжээнүүдээс хүүхдийн “Жаргалант” зуслангийн төсөл нь зөвхөн захиргаа, аж ахуй, гал тогооны барилга баригдсан, 2, 3 шатны ажил буюу хүүхдийн амрах байр, тохижилтын ажлууд хийгдсэнээр бүрэн ашиглах боломжтой, бусад арга хэмжээнүүд нь зориулалтын дагуу ашиглаж, үйл ажиллагаа явуулж байна.

**В.2 Хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүд нь орон нутагт хэрэгцээ шаардлагатай хөрөнгө оруулалтууд болсон байна.**

Улсын төсвийн хөрөнгөөр эрх шилжин ирсэн 6 төсөл арга хэмжээнээс 5 төсөл арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрч 1 төсөл арга хэмжээ нь 70 хувийн гүйцэтгэлтэй ажил зогссон байна.

Хүснэгт № 5 Төсөл, арга хэмжээний хэрэгцээ шаардлагын талаар

№	Төсөл арга хэмжээний нэр	Хүн амын үзүүлэлт, ач холбогдол
1	Хүүхдийн “Жаргалант” зуслангийн захиргаа, аж ахуй, гал тогооны барилга /Булган/	Булган аймгийн статистик тоо үзүүлэлтээс харахад 2023 онд 8-10 насны 3893, 11-13 насны 3493, 14-17 насны 3402 нийт 10788 хүүхэд байдаг.
2	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 75 ор /Булган, Булган сум, 3 дугаар цэцэрлэг/	Булган аймгийн Булган сумын 3 дугаар цэцэрлэг нь 4-р багт байршилтай тус багт 0-5 насны 200, цэцэрлэгийн насны 108 хүүхэдтэй бүртгэлтэй байдаг.
3	Засаг даргын Тамгын газрын барилга /Булган, Баян-Агт сум/	Баян-Агт сум нь нийт 3307 хүн амтай, сумын төвд 201, хөдөөд 768 нийт 969 өрхтэй
4	Ахмадын өргөөний барилга /Булган, Булган сум/	Аймгийн ахмадын хороо нь үйл ажиллагаагаа явуулж байна. Булган аймгийн хэмжээнд 60 дээш насны 6767 ахмад настан амьдарч байна.
5	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 75 ор /Булган, Гурванбулаг сум/	Булган аймгийн Гурванбулаг сум нь багт 0-5 насны 408, цэцэрлэгийн насны 284 хүүхэд бүртгэлтэй байдаг. Үүнээс зөвхөн сумын төвд бүртгэлтэй цэцэрлэгийн насны 90 хүүхэд амьдардаг байна.
6	Үерийн далан /Булган, Сайхан сум/	Сайхан суманд 2008, 2016 онуудад их хэмжээний үер бууж иргэн аж ахуйн нэгжид их хэмжээний хохирол учруулж байсан, тус сум нь 3420 хүн амтай, сумын төвд 686 хүн, 227 өрхтэй байна.

Дээрх төсөл арга хэмжээний ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг авч үзэхэд аймгийн хэмжээнд зусланд хамрагдах насны хүүхэд дунджаар 10788 хүүхэд байдаг байна. Тус зуслан нь 1961 онд ашиглалтад орж байсан үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр хаасан, эхний шатны санхүүжилтээр захиргаа аж ахуй, гал тогооны барилга баригдаж дууссан байна.

Ашиглалтад орсон 2 цэцэрлэгийн хувьд хүүхдийн хүрэлцээ, хангалтгүй харьяа сум, багийн хүүхдийн тоонд харьцуулахад 50-70 хувийг хамруулах хүчин чадалтай хичээлийн байртай байсан бол Булган сумын 3 дугаар багийн цэцэрлэгийн насны хүүхэд бүрэн хамрагдах боломжтой болж, Гурванбулаг сумын цэцэрлэг сумын төвийн цэцэрлэгийн насны 90 хүүхэд бүрэн, хөдөөгийн багаас 15-20 хамруулах хүчин чадалтай болсон байна.

### **ДҮГНЭЛТ:**

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- УИХ-ын 88 дугаар тогтоолын дагуу магадлалаар материалын зөрүү олгох санхүүжилтийг магадлалын дүгнэлтийн дагуу олгосон байна.
- Булган сумын 3 дугаар цэцэрлэгийн барилгыг улсын комисс ажиллаж дутуу ажлыг дуусгах үүрэг даалгавар өгсөн ч хэрэгжилт хангалтгүй, барилгыг хүлээн аваагүй байна.
- Сайхан сумын үерийн далангийн ажил байгалийн гамшгаас үүдэн ажлын тоо хэмжээнд өөрчлөлт орсонтой холбоотой зогссон байна.
- УТХО-аар хэрэгжсэн 4 төсөл арга хэмжээний НББ-д тусгасан дүнг 2023 онд олгосон санхүүжилтийн 763.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж бүртгээгүй байна.
- Хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн бүтээн байгуулалтын ажлууд нь үр ашгаа өгч, төрийн үйлчилгээний хүртээмж сайжирсан байна.

### **ЗӨВЛӨМЖ:**

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна.

Аймгийн Засаг дарга Б.Ариун-Эрдэнэ, ГХБХБГ-ын дарга Ү.Бямбасүрэн нарт:

- ❖ Булган сумын 3 дугаар цэцэрлэгийн дутуу ажлыг гүйцэтгэгч компаниар хийлгэж, улсын комисс дахин ажиллуулж, ашиглагч байгууллагад холбогдох бичиг баримтыг хүлээлгэн өгч бүртгэлд тусгах.